

**Орон нутгийн авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох тухай санал**

Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалтад “Орон нутгийнчанартай авто зам гэж аймгийн нутаг дэвсгэр дэх хот, сум, суурин газар, фермерийн аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн баазыг хооронд нь холбосон болон тэдгээрийн доторх авто замыг хэлнэ”, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт “Нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ”, 25.2.5 дахь заалтад “Нийслэл, **орон нутгийн авто зам, зогсоол ашигласны төлбөр**” гэж заажээ.

Мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “Нийслэл, **орон нутгийн чанартай** авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах замын чиглэл, замынурт, төлбөрийн хэмжээг тухайн **аймаг**, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно” гэж заажээ.

Үүний дагуу нийслэл болон зарим аймаг авто зам ашигласны төлбөрийн хувь хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тогтоон, Нийслэл, орон нутгийн чанартай болонавто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах үйл ажиллагааны журмыг аймаг, нийслэлийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлж байна.

Бусад аймгийн тогтоосон үнийг жишиг болгон аймгийн Татварын хэлтсийн судалгаанд тусгасан 2020 оны хүлээгдэж буй тээврийн хэрэгслийн тоогоор тооцож үзэхэд дараах байдалтай байна.

Д/д	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл	Тээврийн хэрэгслийн тоо					Бусад аймгийн тогтоосон жишиг үнэ	Боломжит орлого
		Авто тээврийн төв		Татварын хэлтэс				
		2018 оны гүйцэтгэл /ширхэг/	2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэл /ширхэг/	2019 оны гүйцэтгэл /ширхэг/	2020 оны төлөвлөлт /ширхэг/	2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэл /ширхэг/		
0	1	2	3	4	5	6	7	8=6*7
1	2 дугуйтай мотоцикл	1959	2521	1355	1360	2103	2.0	4206.0
2	3 дугуйтай мотоцикл			0	0	0	2.0	-
3	<b>Суудлын автомашин:</b>	<b>7425</b>	<b>9652</b>	<b>4895</b>	<b>5165</b>	<b>6378</b>		-
4	а. 2000 см3	3876	5390	3916	4016	5123	15.0	76845.0
5	б. 2001-3000 см3	2973	3511	476	530	568	30.0	17040.0
6	в. 3001 дээш см3	576	751	503	619	687	35.0	24045.0
7	Микро автобус /15 хүртэл суудалтай/	455	515	157	181	194	30.0	5820.0
8	Автобус			54	61	69	80.0	5520.0
9	<b>Ачааны автомашин</b>			<b>2089</b>	<b>2389</b>	<b>2839</b>		-
10	1 хүртэл тн			984	1138	1481	20.0	29620.0

/мян.төгрөг/

11	1-2 тн	3816	4726	203	241	292	25.0	7300.0
12	2-3 тн			91	110	129	30.0	3870.0
13	3-5 тн			162	179	194	35.0	6790.0
14	5-8 тн			241	259	270	40.0	10800.0
15	8-10 тн			230	267	273	45.0	12285.0
16	10 тн-с дээш			178	195	200	50.0	10000.0
19	Тусгай зориулалтын автомашин	189	210	468	479	489	40.0	19560.0
20	Трактор, өөрөө явагч хэрэгсэл	86	123	62	66	46	50.0	2300.0
21	Бага оврын трактор	148	157	41	49	16	30.0	480.0
22	Чиргүүл /1 тн тутмаас/	1233	1279	470	481	163	30.0	4890.0
	<b>Нийт дүн</b>	<b>15311</b>	<b>19183</b>	<b>9591</b>	<b>10231</b>	<b>12297</b>		<b>241371.0</b>

/Эх сурвалж: Авто тээврийн төв, Татварын хэлтэс, 2020 оны 11-р сарын 17-ны байдлаар/

Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт заасны дагуу **орон нутгийн чанартай** зам ашигласны төлбөрийн хэмжээг аймгийн ИТХ-аас тогтоож, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нийслэл, орон нутгийн чанартай болон авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах үйл ажиллагааны журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж, мөрдүүлнэ” гэж заасны дагуу аймгийн Засаг дарга зам ашигласны төлбөрийн хэмжээг мөрдүүлснээр орон нутгийн төсвийн орлогыг **241.3 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байгаа юм.